

МОНГОЛ АРДЫН ХАНДАРМАА ДУУНЫ ДОМОГ

Д.Баасанжав

Дээр үеэс манж эзний хууль цааз зорилгыг зөрчсөн гэж ялд унасан хэн ч бай, хатуу эрүү шүүлт үзэж эрэмдэг зэрэмдэг болж зовж тарчилсан хорлогдох, цөлөгдөх, цаазлагдах зэрэг түмэн зовлон амсан байсан эрчүүдийн нэгэн адил, олон зуун охид, бүсгүйчүүд, эхчүүд, эрх чөлөөгүй зовж явсныг харуулсан. Монгол ардын нэгэн богино дуунд юу гэж өгүүлснийг нь эхлээд өгүүлье.

Алаг морь

Алаг морь минь байгаасай даа хө

Арван хошуу чи юм ч үгүй дээ хө

Аав таньдаа очиндоо гэсэн чинь

Аравны даргаас чөлөөгүй байна хө

Хонгор морь минь байгаасай даа хө

Хорин хошуу нь ч юм ч үгүй дээ хө

Хонгор ээжидээ очиндоо гэсэн чинь

Хорины даргаас чөлөөгүй байна хө

Алаглуулаад оёсон юмаа хө

Арслан хээтэй алчуураа хө

Аав таныхаа амар мэндийг

Асууж суугаад оёсон юмаа хө

Эрээлүүлээд оёсон юмаа хө

Эрээн хээтэй алчуураа хө

Ээж таныхаа амар мэндийг

Эрж суугаад оёсон юмаа хө гэж дуулдаг. Энэ дуунд тохиолдсон

шиг хүслээрээ биш хүнийг эрхэнд будантай цагийн сүүдэр сүүдэрлэсэн үед сэргэлэн ухаанаараа сөрөн ялж, дуу зохиож дуундаа мөнхөрсөн нэгэн бүсгүйн домог олон жарныг өртөөлөн хүрээнд яригдсаар зохиосон дуу нь дуулагдсаар ирснийг энд өгүүлье. Дээр үед хүрээний чинээлэг айлд төрж өссөн залуухан Хандаа хэмээх бүсгүй аавтайгаа хоёулаа амгалан гацаанд амьдран суудаг байж, багаасаа өнчирч аавдаа эрхлэн өссөн хэдий ч Хандаа үйлэнд уран үгэнд цэцэн үзэсгэлэнтэй царайлаг төрсний дээр тэр үедээ хүрээний боловсролтой соёлтойд тооцогдсон бүсгүй байжээ. Хандаа бас бие гүйцсэн хойноо, Амгалан гацаан дахь Тамхины баян

худалдаачныд данс тооцоо хөтлөгч Сүрэгчин хошууны нэгэн залуутай танилцаж хожимоо хайр сэтгэлтэй болжээ. Хайр сэтгэлтэй болсон хоёр залууг уулзаж учрахыг нь олон удаа харсан тамхины худалдаачин баян данжаад нэгэн өдөр ихэд баярласан бахдсан царайтай тэр хоёр дээр ирж яасан сайхан яасан гоё хүүхэн бэ? Манай залуу яасан их азтай байна ийм хүүхнийг би Бээжинд харсан ийм жаахан ар Монголын хүрээнд ийм хүүхэн байна гэхэд би итгэмгүй дотор газар Долон-нуур Бээжинд нэг хоёрхон байна, аяа энэ сайхан царайнаас алт мөнгө аяндаа л асгарна гэж ээ. Эцэг шигээ хүний энэ үгийг хэн, хэн нь тоосонгүй өнгөрч гэнээ. Тэр цагаас хойш хэдэн сарын дараа нөхөр болох залуу Данжаад нь Хөх хотод данс тооцоо нийлэх ажлаар явуулах болжээ. Данжаадын даалгасан ажлыг эсэргүүцэх хэн байлаа даа, нөгөө залуу явжээ. Тэр цагаас хойш Хандаа нөхөр болох залуугаа асууж, данжаадын пүүсээр ирэхэд улам бүр эелдэг сайхан аашлах болж эмэгтэй хүнд ажиглагдам зан ааш нь мэдэгдэж битүү үг хаях болсонд эцэг шигээ настай хүнийг яавал гэж бодоод, мэдсэны мэдээгүй царай гарган нөхрөө асууж сурж гүйсээр хэдэн сар жил болжээ. Нэгэн өдөр Данжаад сэтгэл нь их зовсон царайтай угтаж уулзахдаа Хандаа минь ямар хүн яаж шийдсэнийг би яаж мэднэ, дотно хүнээ хүлээгээд хүлээгээд хэрэггүй тоогүй муу юм болсон байна гэхэд Хандаа ихэд сандарч асуухад Данжаад хай амьд нь ч амьдаа шүү, аяа чи тэрнийг мэдэхгүй ба бага сага мэднэ шүү чиний тэр хүн чинь манж зургааны мэдлийн босуул, Өвөрлөгч хошууны хүн шүү, тэнгэр эзний зарлиг зөрчих хүн хаа байна. Манж эзний хөх тугийн цэрэгт дайчилсан сурагтай, тэр цэрэгт явсан хүн насаараа явах ёстой шүү ийм сайхан хүүхэн эр нөхрөөр юу хийнэ. Мөнгөө мөнгө байна нөхөр нөхөр юу хийнэ бэ, өвгөн миний өчүүхэн хөрөнгийг өөрийн юм шиг үрж болно гэхэд Хандаа ихэд гомдон уйлсаар гэртээ ирснээс хойш олон жил болжээ. Энэ хооронд Хандаа хүрээний нэгэн баян залуу худалдаачин танилцаад байжээ. Тамхины худалдаачин баян пүүсний өвгөн данжаад Хандааг өөртөө татах гэж хүн явуулж эргэж тойруулан бэлэг сэлт өх гэж оролдсоор байжээ. Нэгэн өдөр Данжаад яаралтай уулзах хэрэг байна гэж хэлүүлснийг дуулаад Хандаа хайртай хүнээсээ хэл сураг дуулах нь гэж горьдсоор очиход, данжаад ганцаархнаа нэгэн тохилог хээнцэр тавилгатай өрөөнд их сайхан зан ааштай угтаж, чи тэр эр нөхөр болох хүнээ их хүлээлээ, би чамайг их хүлээлээ, чи хөгшин намайг яаж тоох вэ, тэр яахав хүүхэн хүн хэдий сайхан ч хөгширнө гэх биш, хөрөнгө мөнгө хэнд байна тэр л залуу мэт явна шүү, чи яаж мэднэ, хөөрхөн

чамд дурласан хөгшин намайг уучил. Сайхан дарс хундага ууж саатаж түр суугаач гэж гуйгаад байхаар нь Хандаа гэгээн цагаан өдөр хүн олон холхисон дэн буудалд яав л гэж бодоод зөвшөөрчээ. Өвгөн данжаад ихэд хөөрч баярлан ижилхэн луу ороож чимсэн алтан хундганд дарс хундагалан Хандаад өгөхдөө цаашаа харснаа хумсныхаа завсараас хундагатай дарсанд юм хийчих шиг болсонд харж суусан Хандаа ихэд гайхаж данжаадыг ааль аашаараа ихэд хөөргөн нүдийг нь хариулж дүйвээлүүлж байгаад хундагатай дарсаа сольчихжээ, тааламжтай нь аргагүй сэтгэл нь хөөрсөн Данжаад хундагатай дарсаа шимж суугаад унтаад өгөхөөр нь Хандаа данжаадын өгсөн дарсыг уусан дүр үзүүлэн сууснаа хана руу нь цацчихаад гараад явчихжээ. Өвгөн данжаад өдөржин, шөнөжин унтаад сэрэхгүй байсаар өглөө өөд болжээ. Ингээд Хандаа хүүхэн хүн амины хэрэгт холбогдож олон сар жил мөрдөгджээ. Хятад амбаны түшмэлүүд болохоор санаатай унтуулах эм өгч данжаадыг хорлосон гэж үзэхэд монгол түшмэлүүд болохоор өвгөн данжаад залуу бүсгүйд сээтэн хаяж бүсгүйг оролдох аргалах гэж унтуулах, хуял тачаал хөдөлгөх түр ухаан алдуулах эм, архи дарсанд нь хольсныг мэдэж сэрэмжилсэн бүсгүй хундагаа сольж хүчиндүүлэх, амиа алдах эрэмдэг болох аюулыг зайлуулж чадсан байна. Өвгөн данжаад хундага солигдсоныг мэдэлгүй хуял тачаал хөдөлгөх унтуулах эмэндээ хөгшин биеийн зүрх нь дийлэхгүй үхжээ гэж үзсэнээс хоёр тал маргалдаж байх үед Хүрээнд нэгэн дуу гарсан нь бидний сайн мэдэх "Ганьхуар цаас" гэдэг дуу байлаа.

Ганьхуар цаасанд боодолтой

Галын улаан дааюур тамхиа хө

Гай түтгэр гав гинж нь

Гараад ирэв ээ хө ай Хандармаа хөө

Галбад үгүй хэрэг гэдэг

Үүнээс мандав аа хөө ай Хандармаа хөө

Ийм сайхан Хандармаагаа бид хаанаас олно доо

Даньхуар цаасанд боодолтой

Дүнсэн улаан дааюур тамхиа хө

Дөчин хоёр дагуултайгаа гайхуулж гарав аа хө ай Хандармаа

Төрд үгүй хэрэг гэдэг нь

Түүнээс л мандав аа хө ай хөөрхий

Ийм сайхан Хандармаагаа бид хаанаас олно доо гэсэн үгтэй ийм дуу гарч хүрээ олны сэтгэл бухимдаж хятадын пүүс дэлгүүрүүд тоногдож хүрээний сайхан хятад амбаны зүг ааш авир ихэд гарсан зэргээс хол Улиастайн амбанд шилжүүлсэн гэх домог яриа байдаг.

Улаа өртөө гэдгээр нь

Улиастайн амбаныг зорьлоо би

Ухаантай буурал аав минь

Уйлаад ганцаараа хоцорлоо гэсэн бадаг байдаг нь ч сонин юм.

Хөгжмийн зохиолч, урлаг судлалын доктор Р.Оюунбат

Сүйх тэрэгний цонхоор

Хайрт эх орноо харан

Хүний эрхшээлд би

Хөндлөн гулд туулсан тухай нэгэн бадаг байдаг тухай ярьсныг бодоход Хандааг Улиастайн амбаны газар аваачиж шүүсэн байж мэдэх юм ямар ч байсан хятад амбаны түшмэдүүд амбаны нэрээр түрээ барьж, Хандаад хүн алсан хэрэг хүлээлгэж, Хандааг цаазлах, цөлөх хүрээнийхэнд пүүс дэлгүүр тоногдсон хэргийг тохох их мөнгө нэхэх гэсэн нь ганьхуар цаас дуунд гардаг шиг олон дагуул, хуягаар сүрдүүлж гайхуулж байсан нь ч үнэн бололтой байдаг. Ийм үед Монгол түшмэлүүд хэргийг задлаж, цаг хожиж үнэнийг олж байсан болов уу гэж боддог. Хандаа шоронгоос аавдаа боржигон Цэцэн вангийн Балжинням захирагчтай уулзахыг гуйж (зарим хүмүүс Да-захирагч гэдэг) аав нь хойно ганц охиныхоо төлөө ийм цагт явалгүй ч яахав дээ. Эцэг нь Балжинням захирагчийг хүрээнд ирсэнийг дуулуут сурж явсаар буусан айлд ирж уулзаж мэнд усаа мэдэж учираа хэлэхэд Балжинням захирагч: Өө-хөөрхий та байсан юм уу. Та дээшээ суу. Улиастайн амбанд хүргэгдэх болсон гэл үү.

Өмнө зүгийнхний ааш хойно

Өнгө мөнгө болсон үед

Үнэхээр хүнд хүчир хэрэг дээ

Үнэнээр явбал

Үхэр тэргээр туулай гүйцэнэ гэдэг биз дээ гэж хэлээд босч, тагш авч цай хийж өх гэснээ больж хятад эрээн шаазан авч

Шаазангийн цай

Хийцтэй бол

Нийцтэй гэдэг билүү гэж хэлээд нударгаа буулгаж аягаа арчих шиг болоод цай хийж өгчээ. Нилээд дуугүй сууснаа өнгөтэй өөдтэйгээ өмсөж зоригтой золбоотой бай гээрэй гэж хэлжээ. Аав нь заргын үг зааж хэлж өх болов уу гэж горьдож суусаар орой болж явах болоход Балжинням түшмэл босож гаргаж өгөхдөө: миний тус болох гэж юу байхав дээ таньдаг мэддэг хүндээ хэлье манай түшмэдүүд хараажийн олны нүдэн дээр ил ийм хэргийг амбаны манж түшмэлүүдийн аманд өгчихгүй байлгүй гэж хэлээд хоцорчээ. Хандмаагийн аав нь ихэд урамгүй охин дээрээ ирж хэлэхэд охин нь гайхаж сууснаа Шаазангийн цай хийцтэй бол нийцтэй гээд нударгаараа арчина гэнээ хятад түшмэдэд мөнгө өг тэгвэл чиний хэрэг хэрэг биш болно гэсэн үг байх нь тийм ч болов уу гэж бодсон юм аав бид хоёрт юуных нь их мөнгө байхав дээ тэгэхдээ л үзээд алдана даа гэж гэнэ. Тэрнээс хойш удалгүй дахин шүүж гэнэ. Хандмаа хуяг харгалзагч хүнээ орхиод ороход амбаны газраас шинэ ирсэн бололтой өвгөжир хятад түшмэл нэг монгол түшмэл хоёр зэрэгцэн суусан байна гэнэ. Нилээд зайтай буланд монгол залуухан хэрэг хөтлөгч болтой суусан харагдана гэнэ урьд өмнө ийм цөөхөн түшмэл байцаахад байдаггүйд гайхаж зогсол: Монгол түшмэл гараад явчихжээ тэгэхээр нь Хандмаа манж амбаны шинэ түшмэлийг ихэд бишэрч итгэсэн шинжтэй:

Тэнгэр язгуурт

Дээд төрөлт

Ихэмсэг мэргэн түшмэл та

Өчүүхэн доорд

Бүсгүй миний

Үйлдээгүй хэргийг

Үнэнээр нь шүүж

Цэцэн мэргэнээр шийдэж

Цээжний минь зовлонгоос салгшаж өгнө үү гэж сөгдөн хэлүүтээ том шижир алтан бугуйвчаа суга татан өмнө нь тавиад хойш ухрахдаа аав минь тавь хүрсэн нуруу нь бөгтийж нүүр нь овон товон цоохортсондоо гэж хэлээд суухад амбаны шинэ хятад түшмэл 50 лангийн бөгтөр ембүү дээр нь өгнө өө гэсэн нууц үгийг ойлгож тавин нас хэцүү нас танай аав тавь хүрсээн гэж суутал, монгол түшмэл орж ирэх чимээнээр алтан бугуйвчаа хурдан нууж их ихэмсэг янзтай ганц хоёр юм

асуусан болж сууснаа энэ хүүхний хэргийг шөнөжин шөнөжин бодож, өдөржин өдөржин үзэж, сая асууж асууж мэдлээ монгол түшмэлийн шийдсэн нь зөв болов оо гэсэн гэнэ. Ингэж энэ хэргийг сэгсэрсэн домогт хүчтэний өмнө хүч хүрэхгүй үедээ цаг хожиж хэргийг сунжиржжлан хөвүүлж хөлд нь зөөлөн суух хөхүүлэн хөөргөх олон аргыг хүрээний монгол түшмэдүүд хослон чадмаг хэрэглэж, хүн ардаа манж амбаны хууль цаазны буурангуй харгис хатуу шийтгэлээс өмөөрч байсан олон домгийн нэг нь энэ билээ. Ингэж хэрэг цайрснаас хойш Хандмаа өрх гэр толгойлж ганц бие амьдарч явахдаа хэрэгт холбогдохын өмнө хүрээнд танилцсан хүнээ хоригдож зовж байхдаа ч хэрэг явдал дуусаж үнэнээ олсон үедээ ч ирнэ гэж хүлээсэн нь талаар болсонд харуусаж гомдсондоо энэхүү "Хандармаа" гэдэг дууг зохиосон гэдэг.

Хандармаа

Хар торгон хамжаарийгаа хө

Харанхуй шөнөөр шаглаад оёвоо хө

Хаяад явахыг чинь мэдсэн бол

Ханзлаад хаях минь яавдаа би

Ай хөөрхий Хандармаа яа хө

Дахилт: Дандаа дий-еэ дандаа юу

Дандаа дий-еэ дандаа юу

Дандаа дий-еэ дандаа юу

Дандаа дий-еэ дандаа юу

Бор торгон хамжаарийгаа хө

Бүрэнхий шөнөөр шаглаад оёвоо хө

Боломжтой боломжгүй чамайг гэсээр

Бодож суусаар би хартай боловоо хө

Ай хөөрхий Хандармаа яа хө

Дахилт:

Бор борхон бялзуухай гэдэг нь

Бургасны оройгоор нь шулагнаад байна хө

Буцаад явахыг чинь мэдсэн бол

Бодож суусны минь гарз нь болов уу даа хө

Ай хөөрхий Хандармаа яа хө

Дахилт:

Саатай торгон хамжаарийгаа хө
 Сартай шөнөөр шаглаад оёвоо хө
 Салаад явахыг чинь мэдсэн бол
 Санаж суусны минь гарз нь болов уу даа хө
 Ай хөөрхий Хандармаа яа хө

Дахилт:

Хуур хуучирыг нь байхад
 Хулсан лимбээр нь юугаа хийхэв дээ хө
 Хуучин амраг минь байсаар байсан бол
 Хувирамтгай чамаар юугаа хийхэв дээ

Ай хөөрхий Хандармаа яа хө ингэж дуулдаг Хандармаа дууны тэр болгон дуулагдаад байдаггүй 5 дугаар бадаг нь анхных нь танилцаж Баян данжаадын хар санааны явуулгаар данс нийлнэ гэдэг нэрээр зайлуулагдсан гэхээр дурлалт хүндээ зориулсан гэхээр байдаг нь сонин. Энэ дуу нь олон янзын үг аятай хэд хэдэн хуйлбараар тарсны дээр өвөрлөгч хошууныхан өөр үг аяар дуулдгийг тэмдэглэх нь зохилтой. Хандмаа сүүлдээ хийдэд гэлэнмаа буюу (хандмаа) болсон гэдэг. Энэ домгийг бичгээр тэмдэглэсэн нэг ч үгүй амаар домоглон ярьж ирсэн нь олон. **Тайлбар:**

1. Хүн амины хэрэгт цөлөгдөж явсан нэгэн эмэгтэй авч яваа харгалзагч нараасаа Боржигон Цэцэн вангийн, Балжинням захирагчтай уулзуулж өгөхийг гуйсан авч яваа хуяг нар нь өрөвдөж зам гажиж уулзуулахад Балжинням захирагч мэнд мэдсэний дараа эмэгтэйг харж харж харьд цөлөгдөхөөр яваа юмаа даа гэж хэлээд босож, хятад эрээн шаазан аяганд цай хийхийнхээ өмнө нударгаараа арчиад шаазангийн цай хийцтэй бол нийцтэй байдаг хойно доо гэж хэлээд цай хийж өгчээ эмэгтэй цайгий нь уучихаад явъя даа гэж гэнэ харгалзаж явсан улс гадаа гараад эмэгтэй загнаж чиний үг заалгана уулзана гэж зам гажиж унаа морны гарз хийлээ гэхэд эмэгтэй-захирагч гуай намайг хараад цөлөгдөж явааг мэдээд хятад шаазанд цай хийж өгөхдөө ембуу хэлбэртэй нударгаараа аягаа арчсан дүр үзүүлж цай хийж өгөхдөө шаазангийн цай хийцтэй бол нийцтэй байдаг юмдаа гэсэн. Би асуух юмаа асууж захирагч гуай тодорхой хариу өглөө. Хятадууд мөнгө цутга тэгвэл чиний хэрэг

хэрэг биш гэж хэллээ гэсэн гэнэ хожим тэр эмэгтэй мөнгө цутгаж хэрэг цагаатгагдсан гэдэг.

2. Хүрээнд хүн амины хэрэгт холбогдсон нэгэн эмэгтэйг цэнхэр хөшигний цаана наанаас байцааж байсан гэдэг. Домог үг бий учир нь тэр эмэгтэй маш үзэсгэлэнтэй байсан учир хөгшин залуу шүүгч хэний ч сэтгэлийг хөдөлгөж чаддаг байснаас тэгсэн гэдэг.

3. Энэ дууны ая аялгууг чагнах бүр харууслын нулимс дуслах шиг хирнээ сэтгэлээ барьж тайтгарал уярал, итгэл зориг нэмэх шиг болдог энэ гайхамшигт дууг судлаач ээ гэж хүссэн юм.